

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах /тусгайлан/	-	-	-	-	-	Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.	100%	100%
1.1.2	"Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам"-ын төсөл	-	Баримт бичиг	БШУ-ы сайдын 2020 оны А/164 дүгээр тушаал	Журам батлагдсан байна.	-	"Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах журам"-ын төслийг	90%	90%

	боловсруулж, батлуулна.						боловсруулан яамны сайтад байршуулан нээлттэй хэлэлцүүлэн санал авч, 2025 оны 05 сарын 06- 15-ний өдрүүдэд сургалтын хөтөлбөр боловсруулсан багийн гишүүд, нийслэлийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгч, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлд, 2025 оны 05 сарын 28- ний өдөр СӨБХ- ийн дарга, мэргэжилтнүүдэд танилцуулан саналыг тусган эцэслэж дууссан. Тус журам нь 2025 оны 5 дугаар сарыг дуустал туршсан Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суурь баримт бичиг бөгөөд хөтөлбөрийн туршилтын үр дүнд нийцүүлэн		
--	----------------------------	--	--	--	--	--	--	--	--

							боловсруулсан. Журмын төслийг батлуулахаар хэлтсийн даргад хянуулж байгаа бөгөөд 6 сард багтаан батлуулна. Хавсралт: 20 файл		
1.1.3	"Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журам" -ын төсөл боловсруулж, батлуулна.	-	Баримт бичиг	БСШУС-ын сайдын 2020 оны А/280 дугаар тушаал.	Журам батлагдсан байна.	-	Тус журмын төслийг боловсруулах үе шатанд санал авах хүрээнд 8 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан. Үүнд: 1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд туршилтын 18 цэцэрлэгийн багш нар хүүхдийн хөгжлийн явцын үнэлгээг хийж буй байдал, үр дүн, өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээг хэрхэн хийж буй	90%	90%

						туршлага, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, СӨБХ-ийн дарга, мэргэжилтнээс өгсөн саналын дагуу сайжруулалт хийсэн. 2025.04.15-ны өдөр БЯ-ы СӨБХ-ийн удирдлага, мэргэжилтнүүд, БСҮХ, БЕГ, БҮТ-ийн мэргэжилтнүүдийн уулзалт, хэлэлцүүлэг; 2. 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Боловсролын яамны СӨБХ-ийн дарга, шинжээч, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, БЕГ-ын мэргэжилтнүүдээс бүрдсэн 13 оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлэг; 3. 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр БЯ-ы СӨБХ-ийн дарга, шинжээч, мэргэжилтнүүдийн уулзалт, хэлэлцүүлэг; 4. 2025 оны 5 дугаар		
--	--	--	--	--	--	--	--	--

							сарын 9-ний өдөр БЯ-ы СӨБХ-ийн дарга, шинжээч, мэргэжилтэн, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд, БҮТ, БЕГ-ын мэргэжилтнүүд, нийт 15 оролцогч оролцсон “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын баг”-ийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг; 5. 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулсан багийн нийт 25 оролцогч цахим, танхимын уулзалт, хэлэлцүүлэг; 6. 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр СӨБ-ын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчийн төлөөлөл нийт 22 оролцогч оролцсон уулзалт,		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хэлэлцүүлэг; 7. 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдөр НБГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, хэлэлцүүлэг; 8. 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр СӨБХ-ээрээ хэлэлцүүлэн өгсөн саналыг тус тус төсөлд тусган үзэслэн боловсруулж дуусгасан болно. Тус журам нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суурь баримт бичиг тул хөтөлбөрийн туршилтын үр дүнг журмын төсөлд тусгахад анхаарч ажилласан ба 6 сард багтаан батлуулна. Хавсралт: 9 файл		
1.1.4	"Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын	-	Баримт бичиг	БСШУ-ы сайдын 2020 оны А/269 дүгээр тушаал	Журам батлагдсан байна.	-	Боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	50%	50%

	үйлчилгээ үзүүлэх журам"-ын төсөл боловсруулж, батлуулна.						журмын төслийг Ерөнхий боловсролын газартай хамтран боловсрууллаа. Тус журмын маягтуудыг эцэслэхэд Боловсролын ерөнхий газар, газар хэлтсийн мэргэжилтэн, цэцэрлэгийн төлөөллөөс санал авч нэгтгэх, хэлэлцүүлэг хийж санал авах ажлыг зохион байгуулж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.5.1-д “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” гэж заасан байх тул сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамтран тус журмыг батлуулахаар		
--	---	--	--	--	--	--	--	--	--

							ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
1.1.5	"Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ын төсөл боловсруулна.	-	Баримт бичиг	-	-	Шаардлагын төсөл боловсруулсан байна.	Хүүхдийн цэцэрлэгт ашиглагдаж буй сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн нэр төрөл, чанар, хүртээмж, орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэхийг судлан, 2025-2026 оны хичээлийн жилд улсын хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн 1410 цэцэрлэгт хэрэгжих "СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд шаардлагатай "Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, наадгайн жишиг жагсаалт" болон "Цэцэрлэгийн хүүхдийн насанд тохирсон үлгэр, зохиол, номын жагсаалт"-ыг судалгааны баг	70%	90%

							бүрдүүлэн боловсруулж, Сургуулийн өмнөх боловсролын Сургадтын хөтөлбөрийн төслийн хэрэглэгдэхүүний жагсаалтад орууллаа. Энэхүү судалгаа, жагсаалтад үндэслэн "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ын төслийг боловсруулж байна. Хавсралт: 13 файл		
1.1.6	Хүүхдийн цэцэрлэгийн багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, мэргэжил дээшлүүлэх журмыг батлуулж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.	-	Баримт бичиг	-	Журам батлагдсан байна.	-	"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам", "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны	100%	100%

						мэргэжил дээшлүүлэх журам”-ыг ерөнхий боловсролын газрын мэргэжилтнүүдтэй хамтран тус тус боловсруулж Боловсролын сайдын 2025 оны А/25 дугаар тушаалаар батлуулсан. Сургалт шатлан гүнзгийрсэн агуулгатай байх бөгөөд төрөлжсөн сургалтыг үндэсний түвшинд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвтэй, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн боловсролын газар багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвтэй хамтран зохион байгуулна. Тус журмыг танилцуулах сургалтыг 2025 оны 2 дугаар сард		
--	--	--	--	--	--	---	--	--

							цэцэрлэгийн багш арга зүйч, эрхлэгч болон аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, мэргэжилтэн нарт тус тус зохион байгуулсан. Хавсралт: 11 файл		
1.1.7	Хүүхдийн цэцэрлэгийн эмч, сэтгэл зүйч, багшийн туслахын албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг боловсруулж батлуулна.	-	Баримт бичиг	-	-	Нийтлэг шаардлагыг боловсруулж батлуулна	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн, хүүхдийн цэцэрлэгийн эмч, сэтгэл зүйч, багшийн туслахын албан тушаалд тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, СӨБХ-ийн албан хаагчдын дунд гурван удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулан сайжрууллаа. Тайлант хугацаанд	50%	70%

							“Хүүхдийн цэцэрлэгийн багшийн туслах, сэтгэл зүйч, эмчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”-ыг батлах сайдын тушаалын төслийг боловсруулсан. Хавсралт: 1 файл		
1.1.8	Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг боловсруулж, батлуулна. (ГБХНХЯ-тай хамтрах)	-	Баримт бичиг	-	-	Нийтлэг шаардлага батлагдсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг ЕБГ-ын мэргэжилтэнтэй хамтран боловсруулахад санал өгч, хэлэлцүүлэгт оролцон, ажиллав. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар,	90%	90%

							Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл (2025.04.11), нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлэхэд оролцсон. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг ЕБГ-ын мэргэжилтэнтэй хамтран боловсруулахад санал өгч, хэлэлцүүлэгт оролцон, ажиллав. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хөгжлийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл (2025.04.11), нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлэхэд оролцсон. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.9-д уг нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан тул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025.05.09-ний өдрийн 1/1974 тоот), хамтран батлахаар албан бичиг хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							Тус байгууллагуудаас батлагдан ирүүлэхийг хүлээж байна. Хавсралт: 2 файл		
1.1.1 0	"Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар" боловсруулж, батлуулна. (ЕБГ болон Санхүүгийн хэлтэстэй хамтарна.)	-	Баримт бичиг	-	"Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролы н сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах заавар" батлагдсан байна.	-	Боловсролын Ерөнхий хууль, Хүүхэд хамгааллын хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээн төрийн болон орон нутгийн өмчийн Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, хуваарилах зааврыг боловсруулан, холбогдох газар, нэгжээс санал авч, хэлэлцүүлсний үндсэн дээр Сайдын 2024 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн А/279 дүгээр тушаа лын дөрөвдүгээр хавсралтаар батлууллаа. Хүүхэд хамгааллын зардал нь хувьсах зардлын	100%	100 %

							санхүүжилтийн бүрэлдэхүүнд анх удаа орж, цэцэрлэгийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд зардлыг ангилж, зохицуулалт хийж өгснөөрөө ач холбогдолтой юм. Хавсралт: 1 файл		
1.2.	Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.	-	-	-	-		Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүллээ.	100%	100 %
1.2.1	Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв	-	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын туршилтын үндэсний	-	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр батлагдсан	Шинэчлэн боловсруулж, туршсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний	90%	90%

	уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусгаж хэрэгжүүлнэ.			хөтөлбөр.		байна.	хөтөлбөр"-ийн агуулга, арга зүй нь Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч үзэл хандлага төлөвшүүлэхэд чиглэж байгаа бөгөөд багшийн гарын авлагад сургалт, үйл ажиллагааг төлөвлөн туршсан. Энэхүү сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулах, турших ажил нь 2024 оны 9 дүгээр сараас 2025 оны 5 дугаар сар хүртэл хийгдсэн бөгөөд хот, хөдөөгийн 18 цэцэрлэгийн 2200 орчим хүүхдийг хамруулан туршиж, туршилтын үр дүн болон хэлэлцүүлэг, экспертүүдийн саналыг тус тус тусган сайжруулалт		
--	---	--	--	-----------	--	--------	---	--	--

							хийгдсэн юм. Мөн 2025 оны 05 сарын 28-ны өдөр Боловсролын сайдаар ахлуулсан “Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн зөвлөл”-ийн хуралдааныг зохион байгуулж, нийт гишүүдэд “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр”-ийн шинэчилсэн төслийг танилцуулж, хөтөлбөрийн төсөлд санал, зөвлөмж авч сайжруулан эцэслэн боловсруулж байна. Цаашид хөтөлбөрийг эцэслэн батлуулах, сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд 1410 цэцэрлэгт		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хэрэгжүүлэх бэлтгэл ажлууд хийгдэж байна. Хавсралт: 25 файл		
1.3.	Сургуулийн өмнөх боловсролыг академик мэдлэг олгоход бус хүүхдийг сургуульд бэлтгэх, зөв хүмүүжлийн хандлага төлөвшүүлэх, зөв хооллолт болон өөрийгөө арчилж чаддаг чадварт сургахад чиглүүлнэ.	-	-	-	-		Сургуулийн өмнөх боловсролыг академик мэдлэг олгоход бус хүүхдийг сургуульд бэлтгэх, зөв хүмүүжлийн хандлага төлөвшүүлэх, зөв хооллолт болон өөрийгөө арчилж чаддаг чадварт сургахад чиглүүлж байна.	100%	100%
1.3.1	Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг батлуулан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана.	867,340,20	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг туршиж байна.	-	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулсан байна.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулах, турших ажил нь 2024 оны 9 дүгээр сараас 2025 оны 5 дугаар сар хүртэл хийгдсэн бөгөөд хот, хөдөөгийн 18 цэцэрлэгийн 2200 орчим хүүхдийг хамруулан туршиж, туршилтын үр дүн болон	90%	90%

							хэлэлцүүлэг, экспертүүдийн саналыг тус тус тусган сайжруулалт хийгдсэн юм. Мөн 2025 оны 05 сарын 28-ны өдөр Боловсролын сайдаар ахлуулсан “Сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн зөвлөл”-ийн хуралдааныг зохион байгуулж, нийт гишүүдэд “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр”-ийн шинэчилсэн төслийг танилцуулж, хөтөлбөрийн төсөлд санал, зөвлөмж авч сайжруулан эцэслэн боловсруулж байна. Цаашид хөтөлбөрийг эцэслэн батлуулах, сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 2025-		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							2026 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд 1410 цэцэрлэгт хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна. Үүнд: СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөний гарган БЯ-ны СӨБХ, БЕГ, БСҮХ, БҮТ-ийн СӨБ хариуцсан мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй "Зөвлөлдөх баг"-ийн уулзалтыг сард 2 удаа зохион байгуулж, үйл ажиллагааны явцын талаар хэлэлцэн ажиллаж байна. Мөн СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөрийн шинэчлэх ажлын хүрээнд Сургалтын үзэл баримтлалд 4 голлох арга зүйг хэрэгжүүлэхээр тусган Засгийн		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						газрын тогтоолоор баталсан. Үүнтэй холбогдуулан Боловсролын яам, Азийн сангийн Хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу "Чанга уншлагын арга зүй" 8 цуврал видео хичээлийг бэлтгэн 2025 оны 05 сарын 30-ны өдрөөс Боловсролын ерөнхий газрын сайтаар багш, эцэг эх, асран хамгаалагчид, олон нийтэд түгээн дэлгэрүүлж эхэллээ. Чанга уншлага нь Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэл яриа хөгжүүлэх агуулгатай уялдаж байгаа бөгөөд хүүхдэд номыг чангаар уншиж өгснөөр хэл ярианы чадваруудыг нь дэмжих ач холбогдолтой юм. Хавсралт: 4 файл		
--	--	--	--	--	--	--	--	--

1.3.4	Цэцэрлэгийн менежмент 2025 арга хэмжээг Үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах.	-	-	Цэцэрлэгийн менежментийн загварыг үндэсний хэмжээнд 30 цэцэрлэгт туршсан.	-	-	Хүүхдийн цэцэрлэгийн менежментийн сайн загварыг туршин хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, байгууллагын болон стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө болон байгууллагын өөрийн үнэлгээнд дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн үнэлгээ хийсэн 2024 оны ажлын үр дүнд шинжилгээ хийсэн. “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам” болон хүүхдийн цэцэрлэгийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын	100%	100 %
-------	--	---	---	---	---	---	---	------	-------

						29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан. “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам”-ын танилцуулга, анхаарах асуудал сэдвээр цахим сургалт зохион байгуулж, 3026 багш, удирдах ажилтныг хамруулан арга зүйн дэмжлэг үзүүлээ. Хавсралт: 6 файл		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг"	29.818.80	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь 72.2 Орчны стандартын шаардлага хангасан	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь 78.0 Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн эзлэх хувь 82	Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг"	100%	90%

	" арга хэмжээг хэрэгжүүлнэ.		эзлэх хувь	цэцэрлэгийн эзлэх хувь 76.9			арга хэмжээг хэрэгжүүллээ.		
3.1.1	Цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх, "Гэрт ойр цэцэрлэг-хамгийн сайн цэцэрлэг" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.	26,753,60	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн эзлэх хувь	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь 72,2 Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн эзлэх хувь 76,9	-	Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй цэцэрлэгийн бүлгийн эзлэх хувь 78,0 Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн эзлэх хувь 82,0	Гэрт ойр цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үе шаттай ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Аймаг, нийслэлийн 1410 цэцэрлэгийн хамран сургалт, бүлэг дүүргэлтийн судалгааг 2025 оны 4-5 дугаар сард хийлээ. Тус судалгаанаас үзэхэд нийслэлийн цэцэрлэгийн нийт бүлгийн 28,9 хувь 36-45 хүүхэдтэй, 9,5 хувь нь 46-аас дээш хүүхэдтэй, 5 аймгийн төвийн зарим цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 30-38 хүүхэдтэй байна. Мөн Боловсролын салбарын 2024-2025 оны статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд 2-5 нас болон 5 настны	70%	90%

						хамран сургалтыг нэмэгдүүлэх, нийслэлийн огт цэцэрлэггүй 12 хороонд цэцэрлэг шинээр барих, салбар бүлгийн зохицуулалт хийх, бүлэг дүүргэлт өндөртэй цэцэрлэгүүдэд хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар СӨБ олгох чиглэлээр аймаг, дүүргийн Боловсролын газрын дарга, мэргэжилтнүүдтэй цахим уулзалт зохион байгуулж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгч ажиллалаа. Мөн БЕГ дээр СӨБ ын хүртээмж хариуцсан мэргэжилтнийг ажиллуулж, 12 аймаг, нийслэлийн 6 дүүргийн Засаг дарга нарт бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэх, хамран сургалтыг нэмэгдүүлэх		
--	--	--	--	--	--	---	--	--

							чиглэлээр Сайдын албан бичгийн төслийг судалгаанд үндэслэн боловсруулж дуусгалаа. Тус албан бичигт: - Бүлэг дүүргэлтийг цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмд заасан тоонд барихад чиглэсэн арга хэмжээ авах - Орон нутгийн хэрэгцээнд нийцсэн шинэ цэцэрлэг барих төлөвлөгөө гаргах. - Одоогийн барилга байгууламжийг өргөтгөх, багтаамжийг нэмэгдүүлэх. - Салбар бүлэг нээх зэргээр хэд хэдэн шаардлагатай авч хэрэгжүүлэх чиглэлийг аймаг, дүүргийн СӨБ-ын үйлчилгээний онцлогт нь тохируулж, хэрэгжүүлэхээр албан бичгийн төслийг боловсруулан		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							хянуулж байна. Хавсралт: 6 файл		
3.1.4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд таван настай хүүхдийг бүрэн хамруулж, нэгдүгээр ангид элсэх бэлтгэл хангана.	-	Хамран сургалтын хувь	94.1	94.1	96.0	2024-2025 оны хичээлийн жилд 5 настай хүүхдийн хамран сургалт 94.1 хувьд хүрсэн. Цаашид Таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулах зорилгоор хамран сургалт улсын дунджаас доогуур нийслэлийн 6 дүүрэг (Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй), 12 аймгийн (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Дундговь, Сүхбаатар) Засаг дарга нарт 2025-2030 онд хүртээмжийг	70%	70%

							тасралтгүй нэмэгдүүлэх чиглэлээр өөрийн орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, зохих арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж, тус судалгаанд үндэслэн Чиглэл хүргүүлэхээр Сайдын албан бичиг төлөвлөн хянуулж байна. Хавсралт: 2 файл		
3.1.5	Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг сайжруулах санал	-	Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	11.660	11.660	13.000	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/224 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгт хувилбарт сургалт зохион байгуулах	50%	70%

	боловсруулна.						журам"-д Нүүдлийн бүлгийн сургалт"-ыг зуны улиралд зохион байгуулахаар журамласан. Иймээс 2025 оны 06-08 дугаар сард Хувилбарт сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, удирдамжийн төсөл боловсруулж, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын үйлчилгээний чанарыг үнэлэх, тавилга тоног төхөөрөмж, гэр болон зөөврийн сууцны аюулгүй байдал, багш, хүүхдийн ном гарын авлага, сургалтын чанар, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулан ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна.		
3.1.6	Сургуулийн өмнөх	-	Баримт бичиг	Сургуулийн	-	Үнэлгээ хийж,	Сургуулийн өмнөх	70%	70%

	боловсролын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, сайжруулах санал боловсруулна.			өмнөх боловсролын сургалтын орчны стандарт MNS 6558;2015		зөвлөмж боловсруулсан байна.	боловсролын сургалтын орчны аюулгүй байдал болон стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх сайжруулах хэрэгцээний судалгааг хийж байна. Судалгаанаас үзэхэд 2024-2025 оны хичээлийн жилд улсын хэмжээнд цэцэрлэгийн зориулалтаар ашиглагдаж буй 1911 барилгын 1608 буюу 84.1 хувь нь стандарт, 303 буюу 15.8 хувь нь стандарт бус барилга байгууламж ашиглагдаж байна. Боловсролын сайдын 2025 оны Журам батлах тухай” А/37 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон		
--	---	--	--	---	--	-------------------------------------	--	--	--

						хөндлөнгийн үнэлгээ хийх журам”-ын сургалтын орчны үнэлгээний шалгуураар өөрийн үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамж, зөвлөмжийг БЕГ- ын мэргэжилтэнтэй хамтран боловсруулж аймаг, нийслэлийн Боловсролын газар хэлтсүүдэд хүргүүллээ. Тус удирдамж, зөвлөмжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 05- ны өдрөөс 05 дугаар сарын 31- ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд нийт 1407 цэцэрлэг сургалтын орчны стандартын хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийсэн бөгөөд 21 аймаг, 9 дүүргээс тайланг хүлээн авч байна. Удирдамжийн дагуу 2025 оны 07	
--	--	--	--	--	--	---	--

							дугаар сард үнэлгээний үр дүнг боловсруулж, сургалтын орчны стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх, сайжруулах санал боловсруулан ажиллана. Хавсралт: 4 файл		
3.2.	Хүүхэд харах үйлчилгээний хүрээнд нялх, балчир насны /2 хүртэл/ хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, 1-2 насны хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг бий болгоно.	150.00	Цогц хөтөлбөр, арга хэмжээний үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн тоо	-	Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн тоо 300		Хүүхэд харах үйлчилгээний хүрээнд нялх, балчир насны /2 хүртэл/ хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, 1-2 насны хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг бий болгоно.	100%	70%
3.2.1	Нялх балчир насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	150.00	Хамрагдсан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн тоо	-	-	300 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох үүднээс Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд	50%	50%

							өөрчлөлт оруулах саналыг бэлтгэн холбогдох яаманд хүргүүллээ. Нэгээс хоёр хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих боломж, хууль эрх зүйн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, амьдралын практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн "Хүүхэд харах үйлчилгээний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл" бэлтгэн ГБХНХЯ-нд 2025 оны 04 сарын 22-ны өдрийн 1-1663 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус саналд Монгол улсад 1-2 насны хүүхдийг харах, асрах үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалт дутагдалтай байгаа нь ээжүүд ажлын байрандаа эргэн орох, залуу гэр бүлүүд ажил		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						хөдөлмөр эрхлэхэд хүндрэл үүсэж, улмаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт буурахад нөлөөлөх гол шалтгаан болж байгаа тул “Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль”-иар энэ үйлчилгээнд хамрагдах хүүхдийн насанд өөрчлөлт оруулах саналыг тусгасан болно. Хуульд өөрчлөлт оруулснаар Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.8-д “Хүүхэд харах үйлчилгээний хүрээнд нялх, балчир насны /2 хүртэл/ хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж, 1-2 насны хүүхдийн яслийн		
--	--	--	--	--	--	---	--	--

							үйлчилгээний хувилбарыг бий болгоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Сайдын хөтөлбөр арга хэмжээний зардалд эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулахаар 135.0 сая төгрөгийн зардал төлөвлөж, сургалтын хөтөлбөр боловсруулсан боловч өөрчлөгдсөн тул сургалтыг зохион байгуулаагүй.		
3.4.	Багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэл, менежментийг сайжруулах "Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээг Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ.	-	-	-	-		агшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэл, менежментийг сайжруулах "Сайн багшийг таны дэргэд" цогц арга хэмжээг Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүллээ.	100%	100%
3.4.1	"Сайн багш-Таны дэргэд" арга	1,000.00	Арга хэмжээний	-	-	20	Монгол Улсын Засгийн газрын	90%	70%

	хэмжээний төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.		хэрэгжилтийн хувь				2024–2028 оны хөтөлбөрийн 2.2.3.1-д “Багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэл, менежментийг сайжруулах ‘Сайн багшийг таны дэргэд’ цогц арга хэмжээг Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ” хэмээн тусгасан байна. Яамны 2025 оны төлөвлөгөө боловсруулах зөвлөлдөх уулзалтаар энэхүү төлөвлөгөөг БНБГ хариуцан боловсруулж, санал авч батлуулахаар болсон. БНБГ аас боловсруулсан Төлөвлөгөөний төсөлд багшийн ажлын чанар, сайн сайхан байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц зорилт дэвшүүлэхэд санал өгч, хамтран ажиллав. Хавсралт: 2 файл		
--	--	--	----------------------	--	--	--	--	--	--

3.4.2	“Багшийн гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөөг хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.	1,000.00	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	-	-	Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ны “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээг батлах тухай” 192 тогтоолоор батлагдсан цогц арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахад Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газартай хамтран ажиллаж байна.Яамны 2025 оны төлөвлөгөө боловсруулах уулзалтаар энэхүү дунд хугацааны төлөвлөгөөг боловсролын 4 түвшинг хамруулан БНБГ боловсруулж батлуулахаар болсон. Төлөвлөгөө батлагдсаны дараа хэрэгжилт, зохицуулалтыг ханган ажилахаар төлөвлөж байна.	90%	90%
-------	---	----------	----------------------------------	---	---	---	--	-----	-----

							Хавсралт: 3 файл		
3.6.	Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ.	-	-	-	-		Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэж байна.	100%	100%
3.6.1	Цэцэрлэгийн бүлгийн, хөгжмийн, биеийн тамирын, тусгай хэрэгцээт боловсролын багшийг гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид бэлтгэж, мэргэшүүлнэ	3,300.00	Мэргэшсэн багшийн тоо	-	-	1500	-Тус хэлтсээс Японы хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаа туршлагаас судлах ажлыг Монголын хувийн цэцэрлэгийн холбоотой хамтран 4 дүгээр сарын 20-28 ны өдрүүдэд 15 удирдах ажилтныг оролцуулан зохион байгууллаа. - СӨБ-ын бүлгийн,	50%	50%

							хөгжмийн багш, удирдах ажилтнуудыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны багш бэлтгэх 3 сургуультай хамтран ажиллах чиглэлээр 1+1 хөтөлбөр, болон богино хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар судлан, Монгол улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ болон МУБИС-тай хамтран ажиллах талаар санал боловсруулж, СӨБ багш бэлтгэх сургуулиудад хүргүүлсэн. Энэ хүрээнд 2025 оны 6 дугаар сарын 23- 29-ний өдрүүдэд тус сургуулиудад ажиллах, цаашид тус сургуулиудад жил бүр багш нарыг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд хамруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							Хавсралт: 1 файл		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	-	-	-		Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа.	100%	100%
4.1.1	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	-	2024 оны хэрэгжилтийн суурь түвшин	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Тайлант хугацаанд СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөрийн шинэчлэх ажлын хүрээнд Сургалтын үзэл баримтлалд 4 голлох арга зүйг хэрэгжүүлэхээр тусган Засгийн газрын тогтоолоор баталсан. Үүнтэй холбогдуулан Бодовсролын яам, Азийн сангийн Хамтран ажиллах	100%	100%

						гэрээнд тусгагдсаны дагуу "Чанга уншлагын арга зүй" 8 цуврал видео хичээлийг бэлтгэн 2025 оны 05 сарын 30-ны өдрөөс, Сургуулийн өмнөх боловсролын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилтийг тайлагнах үр дүнгийн хэлэлцүүлгийг 2025 оны 06 сарын 06 -ны өдөр орон даяар цахимаар шууд дамжуулалтыг Боловсролын ерөнхий газрын сайтаар тус тус багш, эцэг эх, асран хамгаалагчид, олон нийтэд хүргэлээ. Мөн шинээр батлагдсан эрх зүйн баримт бичиг, зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг харьяа байгууллага, СӨб-		
--	--	--	--	--	--	---	--	--

						ын багш, удирдах ажилтны цахим группээр олон нийтэд хүргэж ажилласан. Мөн хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актуудын төсөлд яамны цахим хуудсаар дамжуулж олон нийтээс санал авах, батлагдсан тушаал шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргэж ажлыг хэрэгжүүлсэн. Хавсралт: 21 файл		
4.2.	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл	-	-	-	-	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй	100%	100%

	ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.						байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлж байна.		
4.2.1	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	-	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагналт.	2024 оны хэрэгжилтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Тайлант хугацаанд Боловсролын салбарын Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажилласан. Хавсралт: 3 файл	100%	100%

Үнэлсэн:

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....
(огноо)

Тайлагнасан:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)